



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2003 оны 09 сарын 23 өдөр

Дугаар 309

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

2003-2004 оны хичээлийн жилээс өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулсан мэргэжлийн комиссын дүгнэлт, "Өндөр хөгжилтэй орнуудад суралцагчдын асуудлаар санал, дүгнэлт гаргах комисс"-ын 2003 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хурлын тэмдэглэлийг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Шадав овогтой Оюунцэцэгийг Австралийн Технологийн Swinburne Их Сургуулийн магистрантурт 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Энэ тушаал гарсантай холбогдуулан Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2003 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн 234 дугаар тушаалын Шадав овогтой Оюунцэцэгтэй холбоотой хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

3. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар баталсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын бодлого, зохицуулалтын газар /М.Баасанжав/-т тус тус даалгасугай.

САЙД


А.ЦАНЖИД

02664